

Байгаль нуур, Сэлэнгэ мөрний сав газар байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын сүлжээний тухай концепц

Улаанбаатар-2014



Empowered lives.
Resilient nations.

Санаачлагч болон дэмжигч:

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр /UNDP/ болон Даян Дэлхийн Байгал
Хамгаалах Сангийн /GEF/ Байгаль нуурын сав газрын хил дамнансан
экосистемийн байгалийн нө ө цийн нэгдсэн менежмент” тө сө л
<http://baikal.iwlearn.org/mn>

Гарчиг

1. Танилцуулга	3
2. ТББ-ын сүлжээний тухай ерөнхий ойлголт	5
3. ТББ- сүлжээ байгуулах тухай концепц	5
3.1. ТББ-ын сүлжээ байгуулах үндсэн зорилго	7
3.2. ТББ-ын сүлжээ байгуулах чиглэлээр хийх үндсэн үйл ажиллагаа	7
3.3. Хүлээгдэж буй үр дүн	
3.4. Болзошгүй хүндрэл, бэрхшээл	8
3.5. Боломжит үр өгөөж	8

1. Танилцуулга

Байгаль нуур, түүний сав газар хамрагдах Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газар нь биологийн олон янз байдал, олон улсын хил дамнасан цэнгэг усны нөөцийн үнэ цэнийн хувьд дэлхийд чухал байр суурь эзэлдэг. Өнгөрсөн болоод өнөө үед энэ сав газрын байгаль хамгаалал, тогтвортой ашиглалтын талаар олон үр дүнтэй арга хэмжээ авч ирсэн хэдий ч сав газрын хэмжээнд усны нөөц, экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалахад хангалтгүй хэвээр байна.

Байгаль нуур, Сэлэнгэ мөрний сав газар уур амьсгалын өөрчлөлт, усны бохирдол, хөрсний эвдрэл бохирдол, амьдрах орчны доройтол зэрэг асуудал байсаар байна. Эдгээр асуудлыг амжилттай шийдвэрлэхийн тулд байгаль хамгаалах үйл ажиллагааг тусгай хамгаалалттай газраар хязгаарлалгүй сав газрын хэмжээнд авч хэрэгжүүлэх нь чухал байна. Тус сав газрын 87% нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагддаггүй бөгөөд энд экосистем болон биологийн олон янз байдлыг хамгаалах тодорхой зорилгогүй байгалийн нөөц ашиглах үйл ажиллагаа үргэлжилсээр байна.

Эдгээр тулгарч буй бэрхшээлийг хоёр улсын хувьд болон хил дамнасан байгаль хамгааллын түвшинд шийдвэрлэхийн тулд хууль эрх зүйн хүрээнд нилээд саад бэрхшээл тулгарч байна.

Даян Дэлхийн Байгаль Орчны Сан (GEF)-гийн санхүүжүүлтээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP), НҮБ-ын Төслийн Үйлчилгээний Алба (UNOPS)-наас хэрэгжүүлж байгаа “Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн байгалийн нөөцийн нэгдсэн менежмент” төслийг Байгаль нуурын сав газар болон Сэлэнгэ мөрний хил дамнасан усны нөөцийг хамгаалах талаар хоёр улсын олон жилийн жилийн хамтын ажиллагааны туршлага дээр тулгуурлан боловсруулжээ.

Өнөөгийн байдлаар, Хөвсгөл нуур болон Байгаль нуурын сав газрын байгаль хамгаалал, менежментийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагууд /ТББ/-ын оролцоо хил дамнасан хамтын ажиллагааны түвшинд хараахан хүрээгүй байна. Хоёр улсын хувьд ТББ-уудын оролцоо зөвхөн өөрийн орны түвшинд байгаль хамгааллын аль нэгэн асуудалд хязгаарлагдмал хүрээнд оролцох төдий байна.



Зураг 1. Байгаль нуурын сав газар

Байгаль нуурын сав газрын Монголын хэсэгт байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон ТББ байгаа боловч хоорондоо хараахан нэгдэж хамтарсан үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна. Тиймээс, “Монголын Усны Форум –Ус хэлц” ТББ-аас “Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн байгалийн нөөцийн нэгдсэн менежмент” төслийн дэмжлэгтэйгээр Байгаль нуурын

сав газрын Монголын хэсэгт байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын сүлжээ бий болгох зорилго тавин ажиллаж байна. Өөрийн орны түвшинд ийм сүлжээ байгуулсны дараа Байгаль нуурын ОХУ-ын хэсэгт үйл ажиллагаа явуулдаг ижил төсөөтэй ТББ-уудын сүлжээтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх нь дараагийн зорилт юм.

2. ТББ-уудын сүлжээний тухай ерөнхий ойлголт

Өнөө үед дэлхий даяар олон чиглэлээр ижил төсөөтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын сүлжээ байдаг. Хэдийгээр ийм олон төрлийн сүлжээ байдаг ч тэдгээрийг яаж байгуулах талаар нэгдсэн засвар байдаггүй байна. Сүлжээ байгууллагууд нь янз бүрийн зорилгоор, янз бүрийн бүтэцтэй байдаг. Тэдгээр нь албан ёсны болон албан бус зөвлөл, холбоо гэх мэт байхын дээр орон нутгийн, бүс нутгийн, нэг улсын, олон улсын гэх мэт олон түвшинд байдаг.

Ялангуяа, ижил төсөөтэй үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд сүлжээ байгуулан ажиллахыг өнөө үед олон улсад ихээхэн дэмждэг болжээ. Учир нь, ихэнх ТББ-ууд жижиг байддагийн зэрэгцээ хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тул тэдгээрийг нэгтгэн сүлжээ байгуулснаар мэдээлэл солилцох, мэдлэгээ хуваалцах, харилцан суралцах, хамтарч шийдэл гаргах зэрэг үр өгөөжтэй болдг. Мөн, аливаа асуудалд хамтын хүчээр нэгдсэн дуу хоолойтой оролцож, ухуулан сурталчлах, оновчтой шийдвэр гаргахад эерэгээр нөлөөлөх зэрэг олон давуу талтай байдаг.

Ялангуяа хөгжиж байгаа орнуудын хувьд ТББ-уудын сүлжээ байгуулахад зарим нэгэн саад бэрхшээлүүд тулгардаг. Тухайлбал, ТББ-ууд ихэнхдээ хөрөнгө босгох, төсөл хэрэгжүүлэх зэргээр хоорондоо өрсөлддөг тул мэдээллээ хуваалцахгүй байх тал гардаг байна.

3. ТББ-ууд сүлжээ байгуулах тухай концепц

Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн “шинэ” хандлагыг хэрэгжүүлэх явцад түүний салшгүй чухал хэсэг болох олон нийтийн оролцоог хангах асуудлыг заримдаа орхигдуулах тал гардаг байна. Зарим орны туршлагаас харахад сав газрын хэмжээнд аливаа асуудлыг төлөвлөх болон шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог сайтар хангаснаар эцсийн үр дүн нь сайн болдог хэдий ч үүнд нилээд цаг хугацаа зарцуулдаг байна. Ялангуяа, ТББ-ууд усны нөөцийн тогтвортой менежмент явуулах талаар олон нийтэд ухуулан таниулахад ихээхэн үүрэг

3.1. ТББ-уудын сүлжээний зорилго

Байгаль нуур, Сэлэнгэ мөрний сав газрыг (Хөвсгөл нуур-Эгийн гол, Дэлгэрмөрөн, Идэр, Хануй, Чулуут, Орхон, Ерөө, Хараа, Туул голын сав газрууд хамрагдан) хамгаалах ТББ-ын сүлжээний зорилго нь хил дамнасан сав газрын усны нөөц, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдал, амьдрах орчин, ландшафтын унаган байдлыг хамгаалахад чиглэнэ.

Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг ханган хэрэгжүүлнэ: Үүнд

- Орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд байгаль орчны чиглэлээр асуудал дэвшүүлэх, улмаар тогтвортой хөгжил, байгаль орчинд ээлтэй шийдвэр гаргахад Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудыг оролцоог нэмэгдүүлэх чадавхийг дээшлүүлэх.
- Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төр, ТББ, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг Сэлэнгэ мөрний сав газрын хэмжээнд нэмэгдүүлэх, мөн ОХУ-ын ижил төсөөтэй байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Ус, байгалийн нөөц, баялгыг тогтвортой ашиглах, байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийн асуудлыг сурталчлан дэлгэрүүлэх зэрэг болно.

3.2. ТББ-ын сүлжээний хийх үндсэн үйл ажиллагаа

Байгаль нуур, Сэлэнгэ мөрний сав газар байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын сүлжээ нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- ТББ-уудын идэвхитэй оролцоог хангасан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- Мэдээ, мэдээлэл солилцох, түгээх;
- Сүлжээг өргөтгөх зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах;
- Сүлжээний гишүүн байгууллагуудын үр дүнтэй асуудал дэвшүүлэх чадавхыг нэмэгдүүлэх;
- ТББ-уудыг Байгаль нуур, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газар хэрэгжиж байгаа хөтөлбөр, төсөл, үйл ажиллагаатай холбох;
- Сэлэнгэ мөрний сав газрын хэмжээнд ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч нийтлэг зорилт, ойлголттой болох;
- Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө босгоход нэгдэн ажиллах;
- ТББ-уудын эв нэгдэл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарч хамтын ажиллагааны түншлэлийг хангах;
- Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байх зэрэг болно.

3.3. Болзошгүй хүндрэл, бэрхшээл

ТББ-ын сүлжээ ажиллахад дараах хүндрэл, бэрхшээл тулгарч болзошгүй юм.

Үүнд:

- ТББ-уудын оролцоог хангахад орон нутгийн болон үндэсний төрийн байгууллагуудын зүгээс дэмжлэг сул байх;
- ТББ-уудын хүний нөөцийн чадавхи, туршлага дутмаг байх;
- Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санхүүгийн бэрхшээл гарах;
- Санхүүжүүлэх байгууллага дутмаг байх;
- ТББ-уудын хамтын ажиллагаа дутмаг байх;
- Байгаль орчин, усны нөөцийн менежментийн чиглэлээр мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байх;
- Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад хүндрэл гарах зэрэг болно.

3.4. Үр өгөөж буюу хүлээгдэж буй үр дүн

ТББ-ын сүлжээ байгуулагдсанаар дараах үр өгөөж гарах боломжтой. Үүнд:

- Байгаль орчин болон усны менежментийн асуудлаар олон нийтийн анхаарал, оролцоо нэмэгдэнэ.
- Оролцогч талуудын мэдлэг, туршлагыг оновчтой ашигласнаар аливаа төлөвлөлт, бодлого, үйл ажиллагааны үр өгөөж сайжирна
- Тухайн үйл ажиллагааг олон нийтийн зүгээс хүлээн зөвшөөрөх байдал сайжирч, нийтлэг зорилготой болно.
- Нээлттэй /ил тод/ шийдвэр гаргах үйл явц сайжирна.
- Тухайн үйл ажиллагааны талаар үл ойлголцол багасч, хэрэгжилт сайжирна. Байгаль орчинд ээлтэй шийдвэр гаргахад хувь нэмэр оруулахад ТББ-уудын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна.
- Мэдээллийн ил тод, нээлттэй байдал сайжирна.
- ТББ-уудын хамтын ажиллагаа олон улсын түвшинд нэмэгдэнэ.